



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№208 /418/

2022.11.17

Цаг үе, үйл явдал

## ЕРӨНХИЙ ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ОФИЦЕРУУД ЧУУЛЛАА



Монгол Улс дотооддоо дээд боловсролтой Ерөнхий цэргийн командын офицерыг сурган бэлтгэж эхэлсний 50 жилийн ой энэ жил тохиож байна.

Уг ойн хүрээнд “Ерөнхий цэрэг Ассоциаци” ТББ-аас мэргэжлийн үнэ цэн, нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлэх, түүнд тулгамдаж буй асуудлыг хамтын хүчээр шийдвэрлэх зорилгоор Ерөнхий цэргийн мэргэжлийн офицеруудын чуулга уулзалтыг ҮБХИС-ийн “Өрлөг жанжин” танхимд зохион байгуулав.

Энэ үеэр “Ерөнхий цэрэг бол Зэвсэгт хүчний тулгуур хүчин болох нь” сэдэвт онол, практикийн бага хурлыг бие бүрэлдэхүүний дунд хэлэлцүүлж эрдэмтэд, алба хаагчид санал хүсэлтээ солилцлоо. Онол практикийн бага хурлыг нээж “Монгол

хурандаа” нийгэмлэгийн тэргүүн, Монгол Улсын гавьяат багш, доктор /Ph.D/ профессор, ҮБХИС-ийн Хүндэт доктор, чөлөөнд байгаа хурандаа Ч.Баатар хэлсэн үгэндээ, “Олон улсын цэрэг, улс төрийн байдал тогтворгүй байгаа энэ цаг үед улс орнууд өөрсдийн аюулгүй байдлыг хангах, Зэвсэгт хүчний бэхжүүлэх тэр дундаа ялалтыг эцсийн мөчид шийдвэрлэх хуурай замын цэргийн үүргийг өндөрт тавих болсон. Иймд манай улс ч мөн адил Ерөнхий цэргийн нэгтгэл, анги тэдгээрийн байлдааны бэлэн байдлыг бэхжүүлэх, хүчин чадал, байлдах урлаг хийгээд сургалтад тавих шаардлагыг өндөржүүлэх нь цэрэг, улс төрийн дээд удирдлагын түвшинд анхаарал хандуулах асуудал болжээ” хэмээсэн юм. Үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний ХЗЦ-ийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал “Ерөнхий цэрэг

нь орчин үеийн Хуурай замын цэргийн суурь болох нь”, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар “Улс орнуудын Зэвсэгт хүчний ерөнхий цэргийн хөгжлийн хандлагыг өөрийн орны Ерөнхий цэргийн хөгжлийн хандлагатай харьцуулах нь”, ҮБХИС-ийн БХУА-ийн захирал бригадын генерал Л.Онцгойбаяр “Монголын цэргийн урлаг, онолын хөгжилд Ерөнхий цэргийн мэргэжилтнүүдийн оруулсан хувь нэмэр” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлэв.

Арга хэмжээний төгсгөлд дээд боловсролтой Ерөнхий цэргийн командын анхдагчид болох 1970, 1972 оны төгсөгчдөдөө хүндэтгэл үзүүлж, “Ерөнхий цэрэг” Ассоциацийн “Дээд боловсрол-50” хүндэт тэмдэг, дурсгалын зүйлийг гардуулж, дурсгалын зураг татуулсан юм.

Ө.НАСАНТОГТОХ



## ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



БХЯ-ны харьяа “Алдар” спорт хороо 2022-2023 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу “Хувь хүний хөгжил” сэдэвт удирдах бүрэлдэхүүний заах арга зүйн цугларалтыг зохион байгууллаа.

Хоёр өдөр үргэлжилсэн тус сургалтад “Алдар” спорт хорооны багш, дасгалжуулагчдын бүрэлдэхүүн “Хувь хүний хөгжил”, “Санхүүгийн боловсрол” гэсэн ерөнхий сэдвүүдийн хүрээнд сургалт, дадлагад хамрагдсаны зэрэгцээ Чингис хааны музейг үзэж сонирхлоо.

Мөн энэ үеэр “Мансууруулах бодис, утаат болон электрон тамхины хор хөнөөлөөс сэргийлэх”, “Цэргийн алба зохион байгуулах заавар, байгууллагын дотоод журам”, “Хувь хүний санхүү” зэрэг сэдвээр холбогдох албаны мэргэжлийн хүмүүс ирж бие бүрэлдэхүүнд мэдээ мэдээллийг хүргэсэн юм.

Ө.НАСАНТОГТОХ



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5	☁️ -8


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 37	☁️ 22

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,430	3,440
EUR 🇪🇺	3,570	3,590
CNY 🇨🇳	476	482
RUB 🇷🇺	53.80	54.10
JPY 🇯🇵	24.20	24.60
KRW 🇰🇷	2.58	2.60

### ЗУРХАЙ



2022.11.17 /ПҮРЭВ ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 24

**НАМРЫН АДАГ ЦАГААН  
НОХОЙ САР  
ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ  
ХӨХ НОХОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ

Наран ургах, шингэх:

08.01-17.13

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хүчин үйлдэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 641,544,502

Эдгэрсэн

Нийт: 621,103,467

Нас барсан

Нийт: 6,620,063

